

Анги, бүлэг.....

шифр.....

**8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа 60 минут

Нийт – 20 оноо

А ХУВИЛБАР

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Ооно шаргачин хоёр

Ооно шаргачин хоёр гэдгийг Мэнэнгийн их талд л барааг нь харав даа. “Ооно шаргачин хоёр огло тогло харайна” гэсэн эртний үлгэрийг гэнэт санан Мэнэнгийн халиун өвсөн дотроос алтан бэлзэг олох мэт баярлаж билээ. Салхи сөрөн сэргэлзэж, анир аван хулжиж, намрын шаргал талдаа алтан амия тээнэ. Дэлхийн хязгаарт хүрчих юм шиг дэгдэж дүүлэн ухаа толгод арлаж өвөрлөн хүч тамираа барна. Салхин дундаа жаргаж яваа нь тэр юм болов уу? Жаргал гэхэд ч бас айdas нүүрлэсэн орчлонд сүүдрээсээ ч цочин бусгах нь адтай. Үгүйрч дундардаг орчлонд үр удмаа үлдээх юмсан гэж утсан чинээ улаан голоо салхин сэвшээнээс хүртэл харамлаж яваа нь тэр биз дээ хөөрхийс.....

..... Зээр сүрэглэхэд Мэнэнгийн тал хөдлөх шиг болдог гэсэн үг “Гэсэр”, “Жангэр” шиг алслах вий гэхээс дахиад л сэтгэлд уйтгар нөмөрнө.

“Ооно шаргачин хоёр огло тогло харайна”. Айсандaa алтан амия харамласандaa харайна. Хоёр их хангайн өрийг цөмлөсөн дэлгэр талдаа л харайна. Энэ чухамдаа эртээ урьдын цагт зээр гэдэг будаа шиг буцалж байсан юм гэсэн, хайрхаан !

Мэнэнгийн талд сүүдэр хүүшилнэ. Сүүдэртэй хамт айdas наашилна. Уул нь уулаараа, тал нь талаараа хорвоод ургахын улаан нарыг халуун бүлээрээ угтаарай. Чамд ерөөл тавья.

Санжийн Пүрэв

1. Эхээс угсарсан нийлмэл үг 4-ийг олж бичээрэй. / 2 оноо /

.....

2. “Зээр сүрэглэхэд Мэнэнгийн тал хөдлөх шиг болдог”- гэсэн өгүүлбэрээс шалтгаан, үр дагаврыг илэрхийлсэн өгүүлбэрийг ялан шалтгааныг илэрхийлсэн бүтээврээр солин найруулаарай.

Шалтгаан –

Үр дагавар –

.....

.....

3. Уулаараа- гэсэн үгийг үгийн бүтцээр задалж тайлбарлаарай. \2 оноо\

.....

.....

4. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээд учрыг тайлбарлана уу. \2 оноо\

.....

.....

.....

5. Дараах үгсийн дүрмийг тайлбарлан бичээрэй. \ 2 оноо \

хүүшилнэ -

ургахын -

тавья -

дотроос –

6. Д.Намдагийн “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ жишээ баримт ашиглан 50 - 60 угэнд багтаан бичнэ үү. \ 5 оноо \

.....

.....

.....

7. Дараах шүлгийг уншаад зөв дараалалд оруулан хөрвүүлж бичнэ үү. \5 оноо \

**8-Р МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа 60 минут

Нийт – 20 оноо

Б ХУВИЛБАР

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Хөрөнгө сахигч

Нүүдэлчин малчин монгол хүнд нохой шиг тустай, үнэнч нөхөр үгүй гэж хэлж болно. Хоточ сайн нохой бол тэр айлын мал сүрэг, эд хогшил, гэр орныг төдийгүй хүнийг нь сахиж хамгаалж байдаг. Малчин айл бүхэн нохой тэжээдэг заншилтай учраас монголд нохойгүй айл байсангүй. Уяаг нь уртасгаж угаадсыг нь нэмэн тэжээсэн нохой гэдэг эзэндээ ээлтэй, чоно хийгээд хулгайд арангатай, айлын хөрөнгө хадгалагч амьд "цоож тулхүүр" гэлтэй.

Иймээс монголчууд эрт дээд үеэсээ нохойг тэжээн гэрийн тэжээмэл амьтан болгож гаршуулаад, амьдрал аж зуулгын хөрөнгөө, амь насаа ч хамгаалуулж байсан түүхтэй төдийгүй хоточ сайн нохойгоо өрхий ам бүлийн тоонд оруулж хүншүүлэн хайрладаг уламжлалтай байжээ. Ийнхүү хүн нохой хоёр эртний өрөөлөөр учирсан анд сайн нөхөд болно. Нохойг хүний төрөлд ойртсон амьтан гэдэг бөгөөд нохой үхвэл хүн, хүн үхвэл нохой болдог гэж хэлэлцдэг.

Малчин айлын ам бүлд багтдаг ач тустай нохойны өөрт нь оногдсон хөрөнгө гэвэл ганц идүүр нь. Нүүхдээ нохойныхоо идүүрийг эсгийд боон сүүлийн тэмээнд ачаалаад "Сүүлчийн тэмээний ачаа хүндээ" гэж хэлүүт хөсөг хөдөлдөг авай. Энэ хэлц нь ачааны буюу идүүрийн хүндийг биш, тэр айлын хамаг хөрөнгө, хүн малыг сахидаг нохойны ганц өмч болсон идүүрт хүндэтгэл илэрхийлсэн хүнлэг ёсны агуулгатай ажээ.

Д. Баттогох

1. Эхээс угсарсан нийлмэл үг 4-ийг олж бичээрэй. / 2 оноо /

.....

2. "Малчин айл бүхэн нохой тэжээдэг заншилтай учраас монголд нохойгүй айл байсангүй." - гэсэн өгүүлбэрээс шалтгаан, үр дагаврыг илэрхийлсэн өгүүлбэрийг ялган шалтгааныг илэрхийлсэн бүтээврээр солин найруулаарай.

Шалтгаан –

Үр дагавар –

.....

.....

.....

3. Үеэсээ- гэдэг үгийг үгийн бүтцээр задалж бүтээвэр тус бүрийг тайлбарлаарай. / 2 оноо /

.....

.....

4. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олж бичээд учрыг тайлбарлана уу. \2 оноо\

.....

.....

.....

5. Дараах үгсийн дүрмийг тайлбарлан бичээрэй. \ 2 оноо \

учраас -

хайрладаг -

сахидаг -

саналаар –

6. Д.Намдагийн "Үрэгдсэнийг хүлээгч" өгүүллэгээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ жишээ баримт ашиглан 50 - 60 угэнд багтаан бичнэ үү. \ 5 оноо \

.....

.....

.....

7. Дараах шүлгийг уншаад зөв дараалалд оруулан хөрвүүлж бичнэ үү. \ 5 оноо \

Түүхэн 5-р
түүхэн 5-р
түүхэн 5-р
түүхэн 5-р
түүхэн 5-р